

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

1. Сумын Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагааг иргэдэд сурталчилах
2. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах тэднийг мэдээ, мэдээллээр хангах
3. Сумын ЗДТГ-аас зохион байгуулж буй ажлын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн ажилтнуудад урьдчилан мэдэгдэх
4. Сумын ЗДТГ-аас зохион байгуулж буй ёслол хүндэтгэлийн арга хэмжээний техник ажлыг зохион байгуулах
5. Сумын ЗДТГ-ын цахим хуудсыг мэдээ мэдээллээр хангах
6. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах тухай хууль, Төрийн нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын тухай хууль тогтоомжтой нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах
7. Иргэд хүлээн авах төвийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах
8. Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах болон иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой программ хангамжийг сайжруулах, мэдээ мэдээллээр холбогдох албан тушаалтныг хангах
9. Иргэд хүлээн авах нэг цэгийн үйлчилгээгээр болон 70346634 утсаар болон цахим хэлбэрээр өргөдөл гомдол гаргасан иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авах, программд шивж оруулах, нэгдсэн бүртгэл хөтлөх, бүртгэлийн хяналт тавих, тэдний өмнөөс өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавин хариуг эзэнд нь эргэн мэдээллэх,
10. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаас шилжин ирсэн иргэдийн санал хүсэлт, гомдол мэдээллийг судлан үзэх, удирдлагыг мэдээллээр хангах, барагдуулах ажлыг зохион байгуулах, эргэн мэдээллэх
11. Өргөдөл гомдлын мэдээ тайланг нэгтгэн гарган тогтоосон хугацаанд холбогдох албан тушаалтанд өгөх, мэдээллээр хангах
12. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг барагдуулах чиглэлээр байгууллага, албан тушаалтанд шаардлага тавих
13. Төрийн үйлчилгээний талаарх мэдээллээр иргэдийг шуурхай хангах